



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 5/10

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Биндэр сумын Засаг дарга С.Эрхэмбаяр 2017 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр, Баянмөнх сумын Засаг дарга М.Цэнгэл 2017 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр ажил хүлээлцсэн тул бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Биндэр сумын Засаг дарга Н.Алтангэрэл, Баянмөнх сумын Засаг дарга Л.Баянмөнх нарыг дээрх өдрүүдээс эхлэн тус тус үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. Ажлаас чөлөөлөгдсөн сумын Засаг дарга нартай ажилласан хугацааны тооцоо хийж, 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгохыг Баянмөнх, Биндэр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА